

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Э-Транс ложистикс хувьцаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх, томилохтой холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулахдаа хууль дээдлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах, адил тэгш хандах, нээлттэй өрсөлдөөний зарчмыг баримтална.

1.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь зөвхөн энэхүү журмын дагуу сонгон шалгаруулалтад орж сонгогдсон хүний асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргана.

1.4. Сонгон шалгаруулалттай холбогдон гарах зардлыг тухайн компани хариуцна.

**Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн
болон хараат бус гишүүнд тавигдах шаардлага**

2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь компаниас хараат бусаар зөвхөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого явуулах үүрэгтэй.

2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч /цаашид “нэр дэвшигч” гэх/ нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан шаардлагыг хангасан байна.

2.3. Тухайн компанийн үндсэн үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээ болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан Компанийн хуульд зааснаас бусад хараат бус гишүүнд тавих шаардлагыг энэ хуульд нийцүүлэн компанийн дүрмээр тогтоож болно.

2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд тухайн компанийн нийт хувьцааны 5 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжээс нэр дэвшүүлэх ба компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, боловсролтой байхаас гадна компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, ирээдүйн зорилт зорилгыг тодорхойлоход туслалцаа үзүүлэх, компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр мэргэжсэн мэргэжлийн боловсролтой байвал давуу талтай байна.

Гурав. Сонгон шалгаруулалтыг зарлах, зохион байгуулах

3.1. Сонгон шалгаруулалтыг зарлах, зохион байгуулах үүргийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо эсхүл Нэр дэвшүүлэх түр хороо /цаашид “Нэр дэвшүүлэх хороо” гэх/ хэрэгжүүлнэ.

3.2. Нэр дэвшүүлэх хороо нь 5 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигч нараас ирүүлсэн ердийн гишүүнд нэр дэвшигч нарын материалыг энэ журмын хавсралтанд заагдсан шаардлагын дагуу ирүүлсэн эсэхэд хяналт тавих бөгөөд хяналт тавьсан

талаарх хурлын тэмдэглэлийг нэр дэвшигчийн нэрсийн жагсаалттай хамт Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

3.3. Сонгон шалгаруулалттай холбогдуулан Нэр дэвшүүлэх хороо дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын жагсаалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, батлуулах;

3.3.2. сонгон шалгаруулалтын зарыг нийтэд хүргэх;

3.2.3. нэр дэвшигчээс ирүүлсэн материалыг хүлээн авч, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

3.3.4. сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлан, дүгнэлтийг үнэлгээний жагсаалтын хамт Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлэх;

3.3.5. сонгон шалгаруулалттай холбогдсон санал, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

3.3.6. шаардлагатай тохиолдолд нэр дэвшигчийн талаар нэмэлт судалгаа явуулах;

3.3.7. сонгон шалгаруулалтын материалыг архивт шилжүүлэх.

3.4. Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалт явуулахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө зарыг өдөр тутмын сониноор дамжуулан нийтэд зарлах бөгөөд үүнд дараах мэдээллийг тусгана:

3.4.1. хараат бус гишүүнд тавигдах шаардлага;

3.4.2. бүрдүүлэх материал;

3.4.3. материал хүлээн авах хаяг, хугацаа, харилцах утасны дугаар, анхаарах зүйлс гэх мэт.

3.5. Нийтэд зарласан мэдээлэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарвал Нэр дэвшүүлэх хороо тухай бүр нь нийтэд мэдээлнэ.

3.6. Нэр дэвшигч нь зар мэдээнд заасан хугацаанд дараах материалыг бүрдүүлж, Нэр дэвшүүлэх хороонд ирүүлнэ:

3.6.1. сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт;

3.6.2. анкет / Төрийн үйлчилгээний албан хаагч бол төрийн албан хаагчийн анкет /;

3.6.3. ажил байдлын тодорхойлолт /ажил эрхэлдэг бол байгууллагаасаа, хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл/;

3.6.4. нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

3.6.5. боловсролын диплом, үнэмлэх, бусад сургалт семинарт хамрагдсан гэрчилгээ, сертификатын хуулбар;

3.6.6. иргэний үнэмлэхний хуулбар;

3.6.7. компанийн засаглалын гэрчилгээний хуулбар;

3.6.8. Хараат бус гишүүнд нэр дэвшигч нь энэхүү журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан тухайгаа нотолсон байх.

3.7. Энэ журмын 3.6-д заасан материалыг дутуу бүрдүүлсэн нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтад оруулахгүй.

3.8. Нэр дэвшүүлэх хорооны гишүүд сонгон шалгаруулалтын үнэлгээг нэр дэвшигч бүрээр хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэх талаар тус тусдаа үнэлэлт дүгнэлт гаргаж, дүнг нэгтгэн Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэж, хамгийн өндөр авсан 3 нэр дэвшигчийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулна.

3.9. Нэр дэвшүүлэх хорооны үнэлгээний хуудсыг энэ журмын хавсралтаар батална.

3.10. Сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр томилохыг хориглоно.

3.11. Хараат бус гишүүнээр сонгон шалгаруулахад улс төрийн хүчин, төрийн өндөр албан тушаалтан, компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс Нэр дэвшүүлэх хороо болон хувьцаа эзэмшигчдийн хуралд аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

НЭР ДЭВШИГЧ НАРТАЙ ХОЛБООТОЙ КОМПАНИТАЙ НЭГДМЭЛ
СОНИРХОЛТОЙ ХУВЬ ХҮНИЙГ БҮРТГЭХ ХҮСНЭГТ

д/д	Овог	Нэр	Холбоо хамаарал	Регистрийн дугаар	Үнэт цаасны дансны дугаар	Хувьцааны тоо ширхэг	Холбогдох утас
1.							
2.							
3.							

**ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

д/д	Нэр дэвшигч нарын нэрс	1. Ирүүлсэн материалын бүрдэл					
		Хүсэлт	Анкет	Ажил байдлын тодорхойлолт	НД-ийн дэвтрийн хуулбар	Боловсролын гэрчилгээ, диплом бусад сургалт төгссөн талаарх материал	Иргэний үнэмлэхний хуулбар

2. Хуулийн шаардлага		3. Ур чадвар			Үнэлгээ	Эзэлсэн байр
Компанийн засаглалын гэрчилгээний хуулбар	КТХуулийн 79 дугаар зүйлийн 79.1 дэх шаардлага хангасан байдал	Ажлын туршлага	Компанийн үйл ажиллагааны чиглэлийн талаарх мэдлэг	Өмнө нь ТУЗ- ийн гишүүнээр ажиллаж байсан туршлага		

Үнэлгээ өгөхдөө Ирүүлсэн материалын бүрдэл болон Хуулийн шаардлага гэх үзүүлэлтүүдэд тус бүр 1 оноо, ур чадварын үнэлгээг тус бүр 5 хүртэлх оноо өгөх ба нийлбэр оноог нэгтгэн байр эзлүүлнэ. Эхний байруудад нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд ур чадварын онооны чанараар эхний 3 байрыг эзлүүлэх ба мөн тэнцсэн тохиолдолд тэдгээр нэр дэвшигч нарын материалыг ХЭХ-аар оруулж шийдвэрлүүлнэ.